

БАТЛАВ:
ХӨШИГИЙН ХОНДИЙН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ЗАХИРГААНЫ
ДАРГА
Я.СУМХҮҮ

**"Буянт-Ухаагаас - 120 мянгатын уулзвар" хооронд зорчих нийтийн тээврийн чиглэлийн автобуснаас түүвэрлэн зорчигч урсгал, ачаалалын судалгааг AI технологийн шийдэлд суурилан хийж, судалгааны аргазүйн зөвлөмж боловсруулах
Ажлын даалгавар**

2024 оны ... –р сарын ... –ны өдөр
Улаанбаатар хот

№

1. СУДАЛГАА ХИЙГДЭХ ҮНДЭСЛЭЛ:

- Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;
- Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл";
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- "20 минутын хот" үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тогтоол, зөвлөмж;

2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааны зорилго нь "Буянт-Ухаа" автобусны буудлаас "120 мянгат" автобусны буудал хүртэлх 12.5 км урттай зам дагуух нийтийн тээврийн үйлчилгээнд хамаарагдаж буй автобусны буудлын цэгүүдийн ачаалал, тус чиглэлд хамаарагдах автобусаар зорчиж буй зорчигчдын урсгалын тоон өгөгдлийн судалгаа хийх, түүврээр сонгосон үндсэн болон туслах чиглэлийн автобусанд зорчигчийн бууж, суусан тоог дэвшилтэт технологиор тоолох, нэгтгэн дүгнэх, аргазүйн зөвлөмж боловсруулахад оршино. Судалгааны агууллагад дараах мэдээлэлийг агуулсан байх. (үүгээр хязгаарлахгүй) Үүнд:

2.1 Захиалагч байгууллагад төвлөрсөн тоон мэдээлэл болон дэвшилтэт технологиор тоолсон тоон мэдээлэлд тулгуурлан хугацааны цувааны шинжилгээг гүйцэтгэж, зорчигч тээврийн автобусны ачааллын оновчлолыг тооцох

2.2 Нийтийн тээврийн хэрэгсэлээр зорчигчийн буусан, суусан тоог түүвэрлэсэн чиглэлийн автобус тус бүрээр тодорхойлох

- 2.3 Тоон мэдээлэлд тулгуурлан зорчигч тээврийн автобусны буудлын байршил болон хоорондын зайн оновчлолыг математик загварчлалаар тодорхойлох
- 2.4 Судалгааны үр дүнд тулгуурлан нийтийн тээврээр зорчигчдын ачаалал, урсгалыг тооцох арга зүйн зөвлөмж, саналыг гаргах
- 2.5 Автобусны үндсэн болон дайран өнгөрөх хэд хэдэн чиглэлийг сонгон авч, автобусаар үйлчлүүлж буй зорчигчдын суусан, буусан тоог тооцох
- 2.6 Бусад чиглэлүүдтэй уулзах хэсэгт зорчигчийн нягтралыг тодорхойлох

3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Судалгааны хамрах хүрээг “Буянт-Ухаа” автобусны буудлаас “120 мянгат” автобусны буудал хүртэлх 12.5 км урттай зам дагуу зорчих нийтийн тээврийн үндсэн болон туслах 4-өөс доошгүй чиглэлээс түүврийн аргаар сонгон авч захиалагчтай зөвшилцөн тодорхойлно.

4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны арга зүйг дараах байдлаар тодорхойлсон бөгөөд доорх агуулгаар хязгаарлахгүй. Үүнд:

- 4.1 Түүврийн арга - Судалгааны түүврийг зорчигчийн ачаалал болон урсгалын ялгаатай байдлын онцлогоор тодорхойлж, зорилтот түүврийн аргаар, захиалагч болон гүйцэтгэгч тал харилцан тохиролцож, судалгааны объектыг сонгоно.
- 4.2 Тоон судалгааны арга - Хугацааны цувааны шинжилгээ, статистик шинжилгээ, математик загварчлалын шинжилгээ – E-views, IBM SPSS 29.0 програм хангамж
- 4.3 Чанарын судалгааны арга – AI-д суурилсан дүрс шинжилгээ судалгаа

5. ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ҮЕ ШАТ

Судалгааны эх олонлог, тоон мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах, аргазүйн зөвлөмж гаргах ажлын чиглэл, үе шатыг дараах байдлаар тодорхойлсон бөгөөд доорх агуулгаар хязгаарлахгүй. Үүнд:

- Захиалагч байгууллагад төвлөрсөн тоон мэдээлэл болон үндсэн болон түүврээр сонгосон чиглэлийн автобусаар үйлчлүүлж буй зорчигчдын суулт, буултыг дэвшилтэт технологийн шийдэлд суурилсан тоолсон үр дүнг нэгтгэн боловсруулах ингэхдээ хугацааны цувааны, статистик шинжилгээ, математик загварчлалын шинжилгээний тохирохоор ачаалалтай цагийн интерваль, гарагын, амралтын өдрийн гэх мэт параметруудийн нөлөөлөлүүдийг тусгасан байдлаар автобусны буудлын ачааллын, байршилын, хоорондын зайн оновчлолыг тооцох
- Захиалагч байгууллагад төвлөрсөн тоон мэдээлэл болон дэвшилтэт технологийн шийдэлд суурилж тоолсон өгөдлийг боловсруулсан үр дүнд тулгуурлан нийтийн тээврийн зорчигч урсгал болон ачаалалын судалгааг хийхэд шаардлагатай тоон


өгөгдлийг цуглуулах, эх олонлогийг сонгох, өгөгдөлийг боловсруулан цэгийн ачаалал, автобусны ачаалал, зорчигч урсгал, чиглэлүүдийн огтлолцох уулзварын зорчигчийн нягтралыг тооцох, оновчлолыг тооцох аргазүйн зөвлөмж боловсруулах.

Хянасан:

Судалгаа төлөвлөлтийн
газрын дарга

Боловсруулсан:

Эдийн засагч



С.Амарсанаа

О.Энхзаяа